



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/131

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2023 оны “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, яамны Хөдөлмөрийн дотоод журмын 4.1.14-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 3 гишүүнтэй байхаар тогтоож, яамны албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Дэд хорооны даргыг хорооны хурлаар хэлэлцэж, сонгохыг дэд хорооны гишүүдэд даалгасугай.
3. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, ажлын тайлан, мэдээг холбогдох газарт хүргүүлж байхыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргын А/96 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ С.ТӨГСДЭЛГЭР



Төрийн нарийн бичгийн даргын  
2023 оны 11 дугаар сарын 30-ны  
өдрийн А/В дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт



Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

С.Сүнчин

ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын дарга;

Э.Цэрэнчунт

ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын  
Хуулийн хэлтсийн Яамны хууль зүйн асуудал  
хариуцсан мэргэжилтэн;

Б.Пүрэвжав

ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын  
Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын  
хэлтэс Лавлагаа шатлалын тусламж үйлчилгээний  
чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн.